

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗАР НУТГИЙН
НЭРИЙН ХЭЛБЭР-УТГАЗҮЙН ОНЦЛОГ**
(Хоёр гишүүнт нэрийн жишээн дээр)

Г.Амарзаяа

Судалгааны үндэслэл, шаардлага

Газар нутгийн нэр (цаашид ГНН гэнэ) нь түүх, соёлын чухал дурсгалын тоонд зүй ёсоор багтдаг бөгөөд тэдгээр нь хэл хэлэнд өөр өөр цаг хугацаанд буй болдгоороо ард түмний олон зууны түүх, байгалийн нөхцөл, түүний оршихуй, мөн хөгжлийн үйл явц дахь материалын болон оюун санааны амьдралыг өөртөө шингээн тусгадаг байна.

ГНН-ийг судлах нь тухайн үндэстэн ястны бусадтай ямар харилцаатай байсныг мэдээлэх харьцааг харуулаад зогсохгүй тухайн газар нутагт амьдран байгаа хүмүүсийн өөрсдийнх нь оюун сэтгэхүй, юм үзэгдлийг нэрлэх уламжлал, амьдралын хэв шинж, ертөнцийг үзэх үзлийг нээхэд чухал нэмэртэй ба түүний судлалын ач холбогдол, шаардлагыг олон эрдэмтэн судлаач цохон тэмдэглэсэн байдаг.

“Нүүдэлчин удамтай монголчууд бид уул усны нэрээ байнга үеэс үед дамжуулан хэрэглэж ирсэн бөгөөтөл тэдгээрийн нэрийн түүх, утга, гарал, хувьсан өөрчлөгдөж ирсэн зүй тогтлыг төдий л анхаарч сайтар судлаагүй. Энэ бүхнийг тодруулан судлах нь эрт эдүгээгийн монгол хэлний нэрлэх чанар, хэлний соёлын уламжлал, залгамжийн онцлог болон утгазүйн судлалд чухал ач холбогдолтой” гэж судлаач О.Сүхбаатар [2001, 21-р тал] ГНН судлалын ач холбогдлыг товч бөгөөд тодорхой тэмдэглэжээ.

Энэ тухай Б.К.Ондар “Топонимический словарь Тувы” толийнхоо өмнөтгөлд: “Газар нутгийн нэрзүй нь нийгмийн түүхтэй салшгүй холбоотой ба газар нутгийн нэр нь тодорхой түүхийн үе шатанд бий болж, цаг хугацаа, хэлбэрийн хувьд хувирч, заримдаа агуулга нь өөрчлөгдөж, хэл, эдийн засаг, соёлын харилцан үйлчлэл, мөн хүмүүсийн шилжилт хөдөлгөөний үр дүнд тодорхой түүхэн үйл явдлаас шалтгаалан бүс нутгийн хувьд тэлж байдаг. ГНН-ийг системтэй тууштай судлах гарцаагүй шаардлагатай бөгөөд энэ нь ард түмний өнгөрсөн түүхийг харж, бусад угсаатан бүлэгтэй ямар харилцаатай байсныг мөшгөн тогтооход тусалдаг” [Ондар, 2004, стр.5] хэмээн ГНН судлалын ач холбогдлыг мөн тодорхой тэмдэглэжээ.

Судлаач Э.Равдан “ГНН нь нийгэм дэх тодорхой хүмүүсийн бүтээл нэгэнт мөн тул тухайн зон олны нэр оноох уламжлал, нийгэм эдийн засгийн зонхилох хэвшил, үзэл суртал, гоозүйн таашаал, ертөнцийг үзэх үзэл, хэлний тогтолцооны өвөрмөц хэв шинж, хэм хэмжээ зэргийг өөртөө тусгадаг” [Равдан, 2007, 38-р тал] гэжээ.

“Угсаатан ястны хэл соёл, шашин шүтлэг, нүүдэл суурьшил, байгалийн баялаг, амьтан ургамалын байршил тархац, үе үеийн танин мэдэхүйн чухал мэдээллийг агуулсан монгол газар нутгийн нэр (цаашид МГНН гэнэ) нь өөрийн гэсэн нарийн тогтолцоотой бөгөөд үүнийг судлахдаа нарийн нягт хандаж, хэл, түүх, газарзүй, угсаатан зүй зэрэг олон ухааны баримтад дулдуйдах шаардлагатай. Учир нь ГНН бол зөвхөн гадаргуугын байдалд дүйцүүлэн өгсөн нэр төдий бус, олон үеийн хэл түүх, шашин соёлын олон давхаргыг гэрчилсэн баримт болно” [Сүхбаатар, 2001(а), 22-р тал] хэмээн судлах үндэслэлийг зохистой тодорхойлсон байна.

Г.Амарзаяа

Ховд их сургууль

amarzaya2000@yahoo.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

Нийгэм оршин тогтнож байгаа үед ГНН байх нь зайлшгүй бөгөөд, түүнийг судлах чухал шаардлагатай бөлгөө. Нөгөөтэйгүүр эдүгээгийн даяаршиж байгаа нийгэмд ГНН-ийг судлах нь зөвхөн нэг орны төдийгүй манай гарагийн аюулгүй байдал, улс түмний тусгаар тогтнолд чухал үүрэгтэй. Л.Түдэв МГНН-ийг судлахын чухлыг хэлэхдээ: “Газрын нэр гэдэг бол түүх, газар зүй, угсаатан судлал, хэл шинжлэл, олон улсын харилцаа, тэр ч байтугай геологи, хайгуулын шинжлэх ухаанд онцгой тус болох өвөрмөц онч дохио юм. Иймээс нэр судлал анхаарал татахгүй үлдэх ёсгүй. Эрдэнэтийн овоо, Төмөртийн уул, Оюутолгой гэх мэтийн монгол нэртэй газруудад одоо томоохон уурхайн ажил өрнөж байгааг бодоод үзэхэд илүүдэх юун!” [Түдэв, 2005] гэж МГНН-ийн мэдээллийн чадавхийг нь онцлон тэмдэглэжээ.

Монгол улсад байдаг үндэстний цөөнх болох х түмэн нь хэл, соёл, шашин, түүхийн хувьд үндэстний олонхоос эрс ялгаатай тул тэдний оршин суудаг Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрэнд онцлог зүйл олон байх нь дамжиггүй. Түүн дундаа ард түмний соёл, хэлний сэтгэлгээний илрэл болдог ГНН-ийг үгийн сангийн болон утгазүйн талаас нь судлан шинжлэх нь миний энэхүү ажлын анхдагч үндсэн зорилго боловч тус аймгийн бүх нэрийг нэг дор бүхий л талаас нь тодорхойлоход хүрэлцэхгүй тул хоёр гишүүнт 5154 нэрийн хүрээнд утга-хэлбэрзүйн ерөнхий судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Уг ажилдаа эрдэмтэн Э.Равдангийн эмхтгэсэн 1970-аад оны үеийн 220000 орчим нэрээс бүтсэн “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”-д (цаашид МГННЗТ гэнэ) бидний судалгаанд хамрагдсан Баян-Өлгий аймгийн 8314 ГНН байсныг шүүн хэрэглэхүүнээ болгов.

Үндсэн хэсэг: Нэрийн бүрэлдэхүүн

Дээр тэмдэглэсэн тольд Баян-Өлгий аймгийн нийт **8314** нэр бүртгэгдсэнээс **6338** буюу 76,2 хувь нь уулын тухайт нэр, бусад нь усны тухайт болон газрын гадаргуутай холбоотой нэр байна.

МГНН-ийн **354** дэвсгэр нэрээс **128** нь буюу 36,1 хувь нь л бүртгэгдсэн байгаа нь өргөн уудам газар нутагтай монгол орны хувьд уул, ус, гадаргууны бүхий л бүтэц нэгээхэн хэсэгт нь дийлэнх нь байхгүй байгаад гайхах зүйлгүй биз. Дэвсгэр нэр гэдэг нь нэг цогц оногдохуйг ижил төстэй бусад олон оногдохуйгаас ялган заагласан нэр юм.

Энэ нутаг Алтайн уулсын эх орон уулархаг бүс учраас. газар нутгийн дэвсгэр нэрийн 50 орчим хувь, нийт нэрийн 70 гаруй хувь нь уулын тухайт нэр байж хамгийн өндөр давтамжтайгаар уулын нэр нь (2007 уулын нэр байгаагаас 973 нь 2 гишүүнт нэртэй) дангаараа нийт нэрийн 4-ний нэгийг нь эзэлж байна. Ам (1585 амны нэр байгаагаас 931 нь 2 гишүүнт нэр), толгой (980 толгойн нэр байгаагаас 668 нь 2 гишүүнт), хяр (308 хярын нэр байгаагаас 203 нь 2 гишүүнт), гол (302 голын нэр байгаагаас 189 нь 2 гишүүнт), даваа (293 давааны нэр байгаагаас 190 нь 2 гишүүнт) удаалж дийлэнх нь уулын тухайт нэрс байна. Уулыг дагаж гол мөрөн маань урсдаг нутаг тул голын нэр цөөнгүй байх нь гарцаагүй.

Үндсэн хэсэг: Нэрийн хэлбэр-утгазүй

Баян-Өлгий аймгийн нийт 8314 ГНН-ийн **5154** буюу **62** хувь нь **2** гишүүнт, 2939 буюу 35 хувь нь 3 гишүүнт, 203 буюу 2,5 хувь нь 4 гишүүнт, 18 буюу 0,2 хувь нь 5 гишүүнт нэр байна. Эндээс бид дийлэнх олонх болох 2 гишүүнт нэрсэд утга хэлбэрзүйн дүн шинжилгээ ерөнхийд нь хийхийг зорьсон ба дараах үр дүн гарч байна.

2 гишүүнт нэр гэдэг нь ГНН-ийн дэвсгэр нэр болон нэг оноосон нэрээс бүтсэн нэрс байх ба эдгээр нэрийг оноосон нэрийн хэлбэр бүтцээр нь дараах ерөнхий ангилалд оруулж үзэж болохоор байна. Үүнд:

- Тэмдэг нэр, дайвар үгээр нэрийг тодосгосон оноосон нэр (1623 нэр буюу 31,4 хувь),
- Өгөх-оршихын тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржсэн оноосон нэр (1002 нэр буюу 19,4 хувь),
- Харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй оноосон нэр (805 нэр буюу 15,6 хувь),

- Жинхэнэ нэрээр нэрийг тодосгосон оноосон нэр (651 нэр буюу 12,6 хувь),
- Өгөх-орших, харьяалахын тийн ялгалын нөхцөлүүдээр хамт хэлбэржсэн оноосон нэр (553 нэр буюу 10,7 хувь),
- Утга, гарал тодорхойгүй үгс 307 давхардаагүй тоогоор (250 нэр),
- Холбогч бүтээвэр -н-ээр хэлбэржсэн оноосон нэр (103 нэр),
- Хасаг үг (100 нэр) байна.

1. Хамгийн өндөр давтамж бүхий тэмдэг нэр, дайвар үгээр илэрсэн 1623 нэрийн тодосгогчийн 567 буюу 35 хувь нь *алаг, бор, буурал, ногоон, саарал, улаан, ухаа, хар, хонгор, хоо, хөх, хүрэн, цагаан, цоохор, цэгээн, цэнхэр, шарга, шар, эрээн, ягаан* гэсэн өнгө зүс илтгэсэн нэр байна. Жишээ нь: *Алаг ам – Сагсай, Алагийн хөндий- Алтанцөгц, Бор ам – Ногооннуур, Борын ам – Ногооннуур, Буурал толгой – Буянт, Ногоон булаг – Булган, Саарал сайр – Булган, Улаан адарга – Улаанхус, Улаагчин булаг – Булган, Улааны ам – Толбо, Улаагчины даваа – Булган, Ухаа хошуу- Дэлүүн, Хар богоч – Булган, Харын гол – Буянт, Хонгор жалга – Бугат, Хоо булаг – Алтай, Хоогийн ам – Алтанцөгц, Хоон жалга – Бугат, Хөх гол – Сагсай, Хөхийн ам – Ногооннуур, Хүрэн завсар – Бугат, Хүрэнгийн ам – Улаанхус, Цагаан говь – Баяннуур, Цоохор сайр – Алтанцөгц, Цоохорын ам – Ногооннуур, Цэгээн гол – Цэнгэл, Цэнхэр нуур – Булган, Шарга ам – Цэнгэл, Шар бөөрөг – Сагсай, Эрээн сайр – Булган, Эрээний хяр- Баяннуур, Ягаан толгой- Цэнгэл.*

Мөн *их, бага, том, жижиг, бяцхан, өнөр, олон, өргөн, нарийн, бүдүүн, урт, богино* гэх мэт тоо хэмжээ овор заасан нэр, *гурван, таван* гэх мэт тооны нэрийн бүрэлдэхүүн, *баруун, зүүн, эхэн, адаг, ар, өвөр, дээд, доод, дунд, урд, хойд* гэх мэт зүг чиг, байр заасан нэр, *баян, битүү, босоо, гүн, хатуу, зөөлөн, ихэр, муруй, мухар, халицай, хөндлөн, хуурай, хүйтэн, хэцүү, цоорхой, нүцгэн, мухар, сайхан, гашиун* гэх мэт бусад тэмдэг нэр, дайвар үгээр илэрч тухайн газар нутгийн онцлогийг тодосгосон оноосон нэрс байна. Жишээ нь: *Тэгш ухаа – Улаанхус, Хагархай ухаа – Алтанцөгц, Хувхай ухаа – Цэнгэл, Хүйтэн үзүүр – Алтанцөгц, Хэцүү үзүүр – Дэлүүн, Том хаг- Толбо, Мухар хамар – Булган, Оготор хамар – Бугат, Сэтэрхий хамар – Булган, Мөлгөр хошуу - Дэлүүн, Таван хошуу – Дэлүүн, Түргэн хошуу – Булган, Хэцүү хөтөл – Бугат, Огцом худаг - Баяннуур, Хавчиг хүнх – Бугат, Арсгар хэц – Улаанхус* гэх мэт.

2. Өгөх-оршихын тийн ялгалын нөхцөл бүхий оноосон нэр /1002 нэр/ удаалж байгаа нь тухайн газар нутгийн агуулгаар нэрлэх тохиолдол Монгол орны түүн дундаа Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрлэлтэд цөөнгүй болохыг харуулж байна. Энд 3 уул, *хошуу* тутмын нэг, 4 *толгой, хяр, ам* тутмын нэг, 5-7 *булаг, гол, даваа, нуур, хад, худаг* тутмын нэг нь өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржсэн нөхцөл бүхий оноосон нэртэй байгаа нь тухайн газар нутагт олон мянган жил суурьшиж ирсэн ард түмэн газар нутагтаа ямар амьтан, ургамал элбэг болохыг газар нутгийн нэрээр дамжуулан мэдээлсээр ирсэнийг харуулж байна. Энэ бүс нутагт *Угалз, Зүр, Могой, Хотон, Хэрээ, Согоо, Тас, Үнэг, Хойлог, Чоно, Тэх, Янгир, Ятуу, Алмас, Баавгай, Ёл, Ётуу, Мануул, Буга, Тарвага, Туулай, Хэрээ, Царцаа, Хандгай, Загас, Бэлтрэг, Хачиг, Аргал, Зүр, Хясаа, Өндөг, Хун* гэх мэт амьтад, *Чихэр өвс, Шарилж, Шивээ, Яргай, Сархиа, Түнгэ, Зээг, Бураа, Таана, Эмгэлж, Дархи* (унанги том мод), *Өлөнт, Харгана, Дэрс, Сонгино, Арц, Бударгана, Буйлс, Бураа, Бургас, Бут, Ганга, Гишүүн, Зээргэнэ, Цэцэг, Өргөс, Өвс, Мод, Түнгэ, Улиас, Харгай, Хожуул, Хус, Хулс, Ургамал, Таань, Бураа, Шивээ, Сухай, Замаг, Шивээ, Боронго, Самар, Хиаг* гэх мэт ургамал байдаг байна.

Мөн газар нутгаа *Хадат, Элст, Бөөрөгт, Хайргат, Хайрт, Чулуут, Хүрэмт, Уст, Цаст, Царт, Мөст, Тошинт, Цохиот, Намагт, Асгат, Нуурт, Харгуй, Зам, Булагт, Даваат, Зүлэгт, Агуйт, Гуут, Гүврүүт, Хэрлэгт, Рашаант, Хавцалт, Хэрлэгт, Ташмалт, Цохиот, Ширэгт, Нурангит, Эрэгт, Даваат, Аралт, Хясаат, Хөтөлт, Шаварт Худагт, Хүрхрээт, Тойромт, Дэгнүүлт, Эрэгцэгт, Гангат, Утаат, Нөмрөгт, Нөрөөт, Нөөлөгт, Сүүдэрт* гэх мэт хавийн газар нутаг, тогтоцоор нь нэрлэх, *Бороот, Нарт, Шуургат, Салхит, Хуйт, Үерт, Дуут, Шуугиант, Цуурайт, Жаварт, Живэрт, Солонгот* гэх мэт давамгайллагч байгалийн үзэгдлээр нь нэрлэх, *Төмөрт, Хүрэмт, Мөнгөт, Зост, Цахиурт, Давст, Мараат, Хужирт,*

Гүрт (төмрийн хүдэр), Билүүт, Хуурайт, Шүүт, Хагт, Гангарт, Балт гэх мэт эрдэс бодисоор нь нэрлэх, *Индэрт, Хөшөөт, Хаалгат, Самбарт, Овоот, Тахилгат, Бурхант, Бунхант, Баганат, Гэрт, Тогоот, Зуухт, Тулгат, Тахилт, Хүрдэт, Хашилгат, Хашаат, Хороот, Хашилгат, Хэнгэрэгт, Сөрт, Ховоот, Цоорт, Ширээт, Айвалт, Бүрхээрт, Алхат, Тэрэгт, Дэрт, Тавагт, Тэвшит, Бумбат, Дөрөөт, Зээгт, Тамгат, Тоорцогт, Цагирагт, Хулт, Уутат, Еэвэнт, Ацат, Шонт, Бууцат, Шанагат, Эмээлт, Дэлт, Нүхт, Сэнжит, Бааст, Өтөгт, Тамгат, Тэрэмт, Нүхт, Булшит, Үүрт, Ичээт, Бичигт, Буурьт, Индэрт, Шагайт, Аргайт, Балинт* гэх мэт аливаа эд зүйлээр нь болон түүнтэй төстэй байгалийн тогтоцоор нь оноон нэрлэжээ.

3. Харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй оноосон нэр (805 нэр буюу 15,6 хувь) цөөнгүй байгаа ба энд *Дашийн адарга – Ногооннуур, Дамдингийн ам – Сагсай, Дамиранжавын ам – Цэнгэл, Омомбойн жалга – Толбо, Донойн ам – Бугат, Авгайн ам – Ногооннуур, Салимын ам – Ногооннуур, Үхэрчиний ухаа – Алтанцөгц, Тугамбайн булаг – Алтай, Гомбын дав – Булган* гэх мэт хүнд хамаатуулан газар нутгаа нэрлэх *Шаазгайн адарга – Ногооннуур, Азаргын ам – Ногооннуур, Боохойн ам – Ногооннуур, Ботгоны ам – Булган, Бөхөнгийн ам – Сагсай, Бүргэдийн ам – Дэлүүн, Бугын хавцал- Алтанцөгц* гэх мэт мал, амьтанд хамаатуулан нэрлэх, *Сайрын уул - Толбо, Талын уул – Ногооннуур, Адарганы үзүүр – Буянт, Байцын ухаа – Улаанхус, Нуурын үзүүр – Ногооннуур, Хавцалын үзүүр – Сагсай, Хоолойн хавцал – Ногооннуур* гэх мэт хавийн газар нутаг тогтоцоор хамаатуулан нэрлэх тохиолдол давамгайлж байна.

4. Жинхэнэ нэрээр илэрсэн нэрийн тодосгогч (651 нэр буюу 12,6 хувь) оноосон нэрүүд нь *Жамбаа хад - Цэнгэл, Гонгор хошуу - Цэнгэл, Амалхан хясаа - Цэнгэл, Эхнэр хясаа - Дэлүүн, Маршил чулуу - Булган* гэх мэт хүнээр, *Бүргэд хошуу - Булган, Хэрээ хөтөл - Дэлүүн, Ёл хад - Алтай, Үхэр хад - Сагсай* гэх мэт амьтнаар, *Дэгээ хамар - Дэлүүн, Тэрэм хад - Ногооннуур, Гэр хясаа - Булган, Аяга цохио - Булган, Эззгий чулуу - Алтай* гэх мэт эд юмаар голдуу шууд оноон нэрлэжээ.

5. Өгөх-орших, харьяалахын тийн ялгалын нөхцөлүүд хамт хэлбэржсэн (553 нэр буюу 10,7 хувь) оноосон нэрүүдийн хувьд өмнө бидний дэлгэрэнгүй тайлбарласан агуулгаар нь нэрлэсэн буюу тухайлбал *Асгатай Ам-ныхаа хавцалыг* хураангуйлан *Асгатын хавцал-Ногооннуур, Ёлтой Уул-ынхаа хавцалыг* хураангуйлан *Ёлтын хавцал - Булган, Хужиртай Ам-ныхаа хөндийг* хураангуйлан *Хужиртын хөндий - Бугат* хэмээн нэрлэсэн байх ба *толгой, нуур, уул, жалга, хамар, хад, хошуу-ны* нэрэнд илэрц багатай *сайр, ам, хяр, даваа-ны* нэрэнд илэрц өндөртэй байна.

6. Монгол болон хасаг хэлний тайлбар тольд тэмдэглэгдээгүй утга, гарал тодорхойгүй үгс 307 (давхардаагүй тоогоор 250 нэр) байгаа ба эдгээр нь хасаг түмэн голдуу амьдардаг энэ бүс нутгийн хүмүүсийн хэлний авиа, дуудлагын улмаас хувьсан өөрчлөгдсөн, эсвэл хуучирсан үг хэллэгүүд байж болох юм. Үүнд: *Ангалаг, Богонодоон, Бодгоно, Бөгдрөгө, Бөөртөг, Бужим, Бажуунайн, Бөдөөлдөгийн, Бэмбийн, Дөнгөрлөг, Дүнгэрдэг, Ерөнгийн, Ёторын, Жалгарын, Жалбагийн, Жонжигийн, Зэгт, Мөндөшийн, Мундуу, Мянгааргын, Манзалын, Мудгуйн, Номтуун, Нөрөөт, Нэмэгийн, Онгоон, Оргот, Өмст, Өмстийн, Өвчөөнөх, Өнгөрцөг, Өсрөг, Соомын, Сайвын, Сариган, Сууль, Сэдэтийн, Сууль, Талдаг, Тайцын, Тордын, Уйлт, Уу, Халган, Ханцангийн, Хардайн, Хасхагийн, Хайсангийн, Халбангийн, Хульжаагийн, Хөмөөгөлийн, Хүжгэнэ, Хүнх, Хэлэнцэгийн, Цармайн, Цөөнгө, Цулгарын, Чогдогийн, Чочирт, Чочиртын, Шазавын, Шонхваан, Ээрлэгийн, Эрэнгэлэгийн* гэх мэт.

Энд мөн *айвалт, ээмийн, нөрөө, живэр, цулгай, ёлгон, саахуу, халхай* гэх мэт тольд тэмдэглэгдээгүй баруун монголын нутгийн аялгууны зарим үг хэллэг байна.

7. Холбогч бүтээвэр *-н-ээр* хэлбэржсэн оноосон нэрс нь (103 нэр) *Тэмээн үзүүр – Дэлүүн, Ботгон хошуу- Булган, Морин толгой – Булган, Гүүн хамар- Бугат, Унаган ам – Булган, Хонин даваа – Цэнгэл, Хурган нуур – Улаанхус, Ишгэн толгой – Ногооннуур, Чонон толгой – Дэлүүн, Зараан ам – Бугат, Булган гол – Булган, Хэрээн ам – Сагсай, Зурман зуух – Буянт, Шаазгайн хөндий – Улаанхус* (харьяалахын тийн ялгалын нөхцөл байж бас болно),

Боохойн ар (харьяалахын тийн ялгалын нөхцөл байж бас болно) – Буянт гэх мэт амьтадтай, Зүрхэн ам - Булган, Чихэн толгой – Ногооннуур, Хүйсэн толгой- Ногооннуур, Элгэн толгой – Ногооннуур, Зүрхэн уул - Алтай, Бөхөн булаг (амьтан байж болно) – Сагсай, Нүдэн булаг – Дэлүүн, Дэлүүн гол – Дэлүүн, Тавхайн сайр – Алтай, Хүйн ам - Дэлүүн, Хотон гол (Баруун монголд ходоодыг хот гэдэг) – Сагсай, Өвчүүн уул – Сагсай, Туруун хөндий - Цэнгэл, Мөрөн хад – Буянт гэх мэт эд эрхтэнтэй, Элсэн адарга – Бугат, Цасан даваа – Дэлүүн, Мараан сайр – Баяннуур, Модон салаа – Улаанхус, Тосон уул – Улаанхус, Торгон үзүүр – Дэлүүн гэх мэт материал хийцтэй, Суман хөтөл - Цэнгэл, Нуман ам - Алтай, Ханан уул - Алтанцөгц, Ачаан даваа - Баяннуур, Тогоон даваа - Цэнгэл, Аяган нуур - Булган, Сүхэн толгой - Сагсай, Гасан толгой (Гадасыг баруун монголчууд гас гэдэг) - Бугат, Ацан уул - Улаанхус, Шанаган уул – Цэнгэл, Бумбан уул – Булган, Хөшөөн хөтөл – Дэлүүн, Уяан хяр – Улаанхус гэх мэт эд зүйлтэй дүйлгэн нэрлэсэн байна.

8. Баян-Өлгий аймаг нь хасаг түмний суурьшин суугаа нутаг учраас хасаг үг /100 нэр/ цөөнгүй байгаад гайхах зүйлгүй бөгөөд эдгээр нь хүний нэрээс авахуулаад эд материалын нэр, тэмдэг нэр, дайвар үгс байна.

Ерөнхий дүгнэлт

Монголчуудын газар нутгаа нэрлэх уламжлалд нүүдлийн соёл иргэншил, бөөгийн шүтлэг болон шарын шашин, байгаль эхээ шүтэх, хайрлан хамгаалах сэтгэлгээ томоохон байр суурийг эзэлдэг. Тэр дундаа эртний хүмүүсийн амьшуулах үзлийн илрэл болсон байгалийн биетийг хүн, амьтны тухайт нэрээр ялган нэрлэсэн нь МГНН-ийн бүрэлдэхүүнд томоохон хэсгийг эзэлдэг бөгөөд Баян-Өлгий аймгийн 2 гишүүнт ГНН-д ам, толгойг оруулан хүн, амьтны бие эрхтний нэр оноосон болон дэвсгэр нэрийн үүргээр орсон 2344 нэр бүртгэгдсэн нь 45 хувийг эзэлж байна. МГНН-д дэвсгэр нэрийн үүрэг гүйцэтгэдэг хүн, амьтны бие эрхтний нэрийн дийлэнх нь буюу 75.8% нь уулын тухайт нэр байдгаас монголчууд газрын биетийг, тэр дундаа уулыг хүн, амьтантай дүйлгэн үздэг болох нь бидний өмнөх судалгаагаар нотлогдсон ба Алтайн уулсын эх орон Баян-Өлгий аймгийн ГНН-нд бие эрхтний нэр 2-ний 1-ийг эзлэх нь гарцаагүй.

Баян-Өлгий аймгийн ГНН нь монгол орны ГНН-ийн ерөнхий хэлбэр, утгаас гажаагүй боловч бидний судалгааны объект болсон 2 гишүүнт нэрсийн хүрээнд харахад хасаг үгийг давуу агуулсан, хувьссан утга тодорхойгүй үг харьцангуй олонтой, баруун монгол түмний нутгийн аялгууны үг хэллэгийг агуулсан зэрэг дээр өгүүлсэн бусад олон онцлогтой байгаагаараа нарийн нягт судалбал үндэстний зонхилох хэвшил, үзэл суртал, гоозүйн таашаал, ертөнцийг үзэх үзэл, хэлний тогтолцооны өвөрмөц хэв шинж, хэм хэмжээний сонин баримт илэрч болох юм.

Товчилсон үгийн товъёог:

МГННЗТ - Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь
МГНН - Монгол газар нутгийн нэр
ГНН - Газар нутгийн нэр

НОМЗҮЙ

Амарзаяа Г. Хүн, амьтны дотоод эрхтний тухайт монгол газар нутгийн нэрийн утга-хэлбэрзүйн судалгаа, (Диссертаци), УБ., 2009

Бадамдорж Д. Монгол хэлний үгийн сангийн утгазүй, УБ., 2006

Батчулуун Д. Хэл шинжлэлийн судалгааны аргагүй. Ховд., 2004

Дашдаваа Д, Равдан Э. Нэр томъёоны тухай, УБ., 1980

Догсүрэн Ч. Монголын газар усны нэрийн тогтолцооны зарим асуудалд, *Studia Mongolica*, Tom.2 (10), Fasc.16, 243-249-р тал, УБ., 1974

Догсүрэн Ч. Орчин цагийн монгол хэлэн дэх уулын тухайт нэр томъёо, Хэл зохиол судлал, 16-р боть, 92-97-р тал, УБ., 1987

Жучкевич В.А. Общая топонимика, Высшая школа, Минск., 1980

Казакевич В.А. Современная монгольская топонимика, Ленинград., 1934

Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь, (5 боть, 8 дэвтэр CD-н хамт, эрхлэн эмхтгэсэн Э.Равдан) УБ., 2004

Мурзаев Э.М. Словарь народных географических терминов, М., 1984

Нансалмаа Н. Үгийн сан судлал, УБ., 2005

Ондар Б.К. Топонимический Словарь Тувы, Абакан., 2004

Равдан Э. Бүтэц хэл шинжлэл, УБ., 2000

Равдан Э. Монголын газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа, УБ., 2004

Равдан Э. МГНН-ийг судлах онолын суурь зарчмууд, МУИС, ГХСС, ЭШБ, №283 (11), УБ., 2007

Равдан Э. Монгол орны газар нутгийн нэрзүй, УБ., 2008 (а)

Сүхбаатар О. Монголын тахилгат уул усны судар оршвой, УБ., 2001 (а)

Сүхбаатар О. Монголын газар усны нэрийн домог, УБ., 2001 (б)

Төмөрцэрэн Ж. Монгол хэлний үгийн сангийн судлал, УБ., 1974

Түдэв Л. Газрын нэр судлалын шинэ ололт, Дал сонин, №205/51, 2005

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, УБ., 1966

Шагдар Ш. Монголын газарзүйн нэрийн товч толь бичиг?, УБ., 2000

Энхбат Д. Нэр судлалын талаарх онолын шинэлэг үзэл баримтлал, МУИС, ГХСС, ЭШБ №180(2), УБ., 2001

Хүснэгт 1

	Дэвсгэр нэр	Хасаг үг	Харьяалахын тийн ялгалын нөхцөл	Өгөх-оршихын тийн ялгалын нөхцөл	Харьяалах + өгөх-оршихын тийн ялгалын нөхцөл	Тодотгогч (тэмдэг нэр, дайвар үг)	Тодотгогч (жинхэнэ нэр)	Холбогч бүтээвэр -н	Толорхойгүй үг	ДҮН
1	Адарга		3		3	6		1		13
2	Ам	17	210	223	149	187	73	5	(67)	931
			Ангалаг, Ангалагийн, Богинодоон, Бодгоно, Бөгдрөгө, Бөөртөг, Бужим, Бажуунай, Бөдөөлдөгийн, Бэмбийн, Дөнгөрлөг, Дүнгэрдэг, Ерөнгийн, Ёторын, Жалгарын, Жалбагийн, Жонжигийн, Зэгт, Мөндөшийн, Мундуу, Мянгааргын, Манзалын, Мудгуйн, Номтуун, Нөрөөт, Нэмэгийн, Онгоон, Оргот, Өмст, Өмстийн, Өвчөөнөх, Өнгөрцөг, Өсрөг, Соомын, Сайвын, Сариган, Сууль, Сэдэгийн, Сууль, Талдаг, Тайцын, Тордын, Уйлт, Уу, Халган, Ханцангийн, Хардайн, Хасхагийн, Хайсангийн, Халбангийн, Хульжаагийн, Хөмөөгөлийн, Хүжгэнэ, Хүнх, Хэлэнцэгийн, Цармайн, Цөөнгө, Цулгарын, Чогдогийн, Чочирт, Чочиртын, Шазавын, Шонхваан, Эзэрлэгийн, Эрэнгэлэгийн, Ээмийн-2							
3	Ангал					1				1
4	Ар		3		1					4
5	Арал	1	1	2		5	1			10
6	Асга		2	2		6				10
7	Богоч		2	4		9		1		16
8	Бөөрөг	1	2		6	7	1			17
9	Булаг	3	9	20	8	37	16	3	(3)	99
		Жигж, Чөрөгийн, Бахлаг								
10	Булан		2	2		2				6
11	Бургас					1				1

12	Бууц					2				2
13	Бэл		2		3					5
14	Бэлчир		2		1					3
15	Ганга			1						1
16	Гануу	1	4			1	1		(2)	9
		Дүнгэрлэг, Борооч								
17	Гатлага								(3)	3
		Тавалдайн, Тавилдайн, Таралдайн								
18	Говь		4	1	2	19		1	(2)	29
		Сумдайргын, Карстын								
19	Гол	3	29	25	46	41	23	1	(24)	189
		Ангираг, Бумбай, Ойгор, Сумдайргын, Хорж, Хуйтас, Хулжаа, Цөнхөл, Чангас, Боорт, Жаргын, Идгайх-2, Постигийн, Увсайн, Халбангийн, Хоромд, Хоромдог, Хөлдөг, Хөлцөөгийн, Чочиртын								
20	Горхи	1	2	6	3		3			15
21	Гуу		1	2		2				5
22	Гүвээ								(1)	1
		Долоодын								
23	Гүүр		1							1
24	Дав		5	1	4	12	2			24
25	Даваа	10	52	22	42	41	6	5	(14)	190
		Дүрвэд, Мансар-2, Сөнхөгийн, Ангирлагийн, Гайшинсарын, Постигийн, Сумдайргын, Ураалгат, Хулжаагийн-3								
26	Дов			1	1	3				5
27	Довон					2				2
28	Дэв					1				1
29	Дэвсэг		4	1		7				12
30	Дэл			1		13				14
31	Дэнж		1	2	1	4				8
32	Дэнжиг					1				1
33	Дэрс				1		1			2
34	Жалга	4	17	14	1	46	12	1	(7)	101
		Аюуг, Жааваа, Мушиг, Хүнх, Соосгойн, Сунгарав								
35	Зааг	1	16		1					18
36	Завсар		1			7	1	1		10
37	Зам					1				1
38	Зоо	1	11	1	12	4			(1)	30
		Боортын								
39	Зуух		3	6	1	13	1	1	(1)	26
		Шазуун								
40	Ирмэг		1			2	1			4
41	Мод					1				1
42	Мудаа					1				1
43	Мухар		1	1		5			(1)	8
		Жигж								
44	Намаг				1					1
45	Нуга					1				1
46	Нуруу	3	14	3	13	7			(8)	47
		Нортын, Сийлхэмийн, Мянгааргын, Ангирлагийн, Жингээн, Чихачевийн, Хэлэнцэг								
47	Нуур	3	11	33	9	105	50	9	(7)	226
		Ангираг, Голой, Кишуя, Постиг, Хөгсөн, Хөлдайяраг								
48	Нүүр					1				1
49	Овоо		1			3			(2)	6

		Овшин, Гонзойн							
50	Олом						1		1
51	Оргил		1	1					2
52	Орой		1						1
53	Рашаан		1						1
54	Сайр	2	34	15	28	78	9	3	(11) 180
		Гүнц, Сургаан, Тавнай, Ураалга, Айвалтын, Дөнгөрөхийн, Дүнгэрлэгийн, Оргот, Ташгайн, Шижигт, Ээлгэний							
55	Салаа	7	10	15	10	65	10	4	(4) 125
		Байжин, Хулжаа, Хулжаан, Хундаатын							
56	Сархиа					1			1
57	Сарьдаг					1			1
58	Суга					1			1
59	Судаг					1			1
60	Таг		1		2				3
61	Тал	2	9	2	5	2	3		(1) 24
		Боортын							
62	Ташуу					3	1		4
63	Тойром			3		8	6	3	(2) 22
		Өнгөрцөг, Жангас							
64	Толгод		18		7	10	1	1	(2) 39
		Барчин, Жиж							
65	Толгой	4	14	146	1	263	192	22	(26) 668
		Аюуг, Баанжуур, Балж, Бодгоно, Гожин, Долонцог, Дүнгэрэв, Жанжигдтүвэй, Муудаа, Номтуун, Пансуурын, Соом, Тайц, Товорцог, Хатлага, Хоромдогийн, Хурамдаг, Айвалт, Баа, Бамбат, Булбат, Тоёотой, Улхан, Хадав, Цэхээн, Ээм							
66	Тохой		4	8	5	8	3		(2) 30
		Ангага, Тэрх							
67	Төвөө						1		1
68	Төгөл					1			1
69	Төхөм							1	1
70	Туурь		1		1				2
71	Түнгэ				1	2	1		4
72	Түргэн					1			1
73	Улиас					1			1
74	Ус		3						3
75	Усан сан		3	2	6		1		12
76	Уул	25	26	323	23	294	177	29	(78) 973
		Автарган, Айвалт-2, Аймагш, Ангирог, Аставжаа, Баарцаг, Бажиг, Базгар, Байжин, Балзгар, Балтгай, Баавай, Бахлагийн, Бөдөөлдөг, Борхотын, Годроо, Долсоо, Дором, Дүнгэрдэг, Дөнгөрөх, Дөнхрөө, Дүнхэр, Ёлгон, Ёрвон, Ёлхын, Ёрвон, Ётор, Жансан, Жингээн, Жиравай, Инчээ, Иргал, Мудгуйн, Назрага, Нэмэг, Озум, Орт, Ортуут, Өвчөөнөх, Соосгой, Саахуу, Сайв, Сумаагийн, Сөнхөг, Сумдайрга, Сээрэгмээ, Тойб, Тойвог, Тэрисак, Ураалгат, Ураалга, Унар, Хасхаг, Хашинга, Хорооног, Хульжаа, Хүүхлэй, Хэлэнцэг -2, Цанжид, Цайлбар, Цөнөг, Цөнхөөгт, Цорогт, Цулгар, Чидал, Чочирт, Чотгор, Шолоог, Шологийн, Шовон, Энгэлэг, Эрэнгэлэг, Ээм-2							
77	Ухаа		4	2	3	15			24
78	Үзүүр		13	19	5	28	3	3	(4) 75
		Баартын, Харалдаагийн, Чондон Ээмийн							
79	Хаваг					1			1
80	Хавирга					2			2
81	Хавцал	1	5	4	5	3			(1) 19
		Үйтган							

МОНГОЛЫН ГАЗРЫН ЗУРАГ, ГАЗРЫН НЭР СУДЛАЛ

82	Хавчуу				1					1
83	Хаг				1	2			(1)	4
		Андархай								
84	Хад		3	11		26	9		(2)	51
		Булхаг, Саахуу								
85	Хажуу				1					1
86	Хамар		11	4	4	19	4	1	(1)	44
		Товоохой								
87	Харгайт					6				6
88	Харгана					1				1
89	Ховдол					1				1
90	Ховол					1				1
91	Хонхор		4	2	3	3			(1)	13
		Хоромд								
92	Хоолой		4	3	2	2				11
93	Хороо					1				1
94	Хотгор		2	1		2				5
95	Хошуу		3	27	3	28	13	3	(1)	78
		Бэсэн								
96	Хөдөө		10		6	2			(1)	19
		Хөлцөөтийн								
97	Хөндий	1	20	3	8	7			(1)	40
		Хилэнцэгийн								
98	Хөтөл	4	52	13	25	49	6	2	(7)	158
		Бятагын, Мудагийн-2, Соосгойн, Хонлойн, Хэлэнцэгийн, Ээмийн								
99	Хөшөө		1							1
100	Худаг	5	23	8	8	6	2		(3)	55
		Могзын, Орогтын, Төнхөөт								
101	Хунх				1	1				2
102	Хунхуй					1				1
103	Хургад					1				1
104	Хуруу					1				1
105	Хус					1				1
106	Хуудас				1	1				2
107	Хүнх			1		5				6
108	Хэц				1	1				2
109	Хяр	9	89	4	68	9	4		(21)	203
		Ангалаг, Балгантын, Борхотын, Байжингийн, Дөнгөрөхийн, Дэржигийн, Мөндөшийн, Жаншитын-2, Иргалын, Өнгөрцөгийн, Сайвын, Сумаагийн, Сээрэгмээн, Ураалгын, Хоромдогийн, Хорооногийн, Ширхэйн, Шижигтийн, Эрэнгэлэгийн,								
110	Хясаа	1	5	5		11	3	2	(1)	28
		Цавчир								
111	Цохио					2	3		(1)	6
		Цайлбарын								
112	Цүнхэг					1				1
113	Чулуу					5	4			9
114	Шил				2					2
115	Ширэг					3				3
116	Энгэр	2	10	3	4	10			(1)	30
		Балчингийн								
117	Эрэг		2	3	1	16	2			24
118	Эрэгцэг					2				2
119	Эх		1		2					3
	ДҮН	100	805	1002	553	1623	651	103	307	5154

SUMMURY

Place names in any area inevitably carry historic and cultural outcomes recorded through and they reflect the history of the people in the area, their spiritual lives and living, development processes and transformations they underwent and their life conditions.

Place names in Bayan-Ulgii province of Mongolia, where khasag people, a national minority in Mongolia with their own language, culture, religion and history that make them distinct from other major ethnic groups in Mongolia, have specifics. The author, a linguist, initially intended to explore the place names in the province with focus on semantics and lexicology, due to the complexity of the study, the author limited the study to the semantic and lexicological characteristics of the place names in the area within the framework of 5154 names that consist of two words (two-member or binary names).

Two-member or binary names are the names that include a geographic ground name and a proper name. On the basis of the findings, 8 different types of the place names in the area were identified namely: names modified by adjectives or adverbs (1623 names or 31,4%), names modified by the nouns with dative case suffixes (1002 names or 19,4%), names modified by the nouns with possessive case suffixes (805 names or 15,6%), names modified by nominative case nouns (651 names or 12,6%), names modified by the nouns with both dative and possessive case suffixes (553 names or 10,7%), names modified by semantically and etymologically indeterminate words (307 names), names modified by linking suffix *-н* (103 names) and names modified by khasag words (100 names).

Though the place names in Bayan-Ulgii province follow the general pattern of forms and meanings of the place names in Mongolia, they have many peculiarities such as containing comparatively many khasag words, western Mongolian dialect words and evolved indeterminate words. Thus, study of these names in depth looking closely at scientific aspects may reveal many interesting and unknown facts of the traditions, customs, aesthetics, and views on the world and language system of this ethnicity.